

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



Үүсгэн байгуулагчийн сургаал

Эргэлзээг үгүй хийх шаргуу бэлтгэл

Чухал тэмцээн болон шалгалтын өмнө “Зүгээр ээ, чадна.” гэсэн сэтгэл болон “уначих вий дээ” гэсэн түгшүүр хоёр хоорондоо харшилддаг. Улмаар нэг л айж түгшсэн бол түүндээ улам бүр автчих гээд байдаг талтай.

Ничирэн Хутагт “Сэтгэл хоёрдвоос юуг ч үл бүтээнэ” хэмээн сургаад, хүний сэтгэлд хоёр сэтгэл цуг байвал хоорондоо сөргөлдөөд юу ч байсан санаснаар бүтдэггүй гэсэн байдаг.

Явал энэхүү сөргөлдөөд байгаа хоёрдмол сэтгэлийг үгүй хийх вэ.

Сүмогийн ертөнцөд бол айдас түгшүүрээ давахын тулд “Дасгал сургууль л хийхээс өөр зам байхгүй” гэдэг. Өөрийн чадлынхаа хирээр хичээллэснээр “Ингэж хичээллэсэн юм чинь гарцаагүй зүгээр” хэмээн барилдаанд давах

сэтгэл зүйн хүчээ олж авдаг.

Хар үүрээс эхлээд элсэнд булхан дэвжээн дээр өнжиж, хөдөлж чадахгүй болтлоо шаргуу бэлтгэл хийснээр мэх сайн эзэмших ба сэтгэлийн эргэлзээ төөрөгдөл ч алга болох нь гарцаагүй юм.

Ямагт хичээнгүй зүтгэлтэй байснаар аливаа сэтгэл зовоосон асуудал, түгшүүр, эргэлзээ тээнэгэлзээг үгүй хийж чадна шүү дээ.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, Х.214-215

Living the Lotus
Vol. 169 (2019,10)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Коочироо

Орчуулсан: Ж.Сэлэнгэ

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаагай гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

“Бурхан”-нд өргөл өргөх

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



“Бурхан” яагаад олон байдаг вэ

Цагаан Лянхуа Судрын “Бурхан болохыг батлах бүлэг”-т Шагжамүни Бурханы шавь нар “Та ч бас Бурхан болж чадна” хэмээн Бурхан болж чадахыг нь батлах “Баталгаа”-ааг олгож буй үзэгдэл хэд дахин давтагдан гардаг. Түүн дунд Шагжамүни Бурхан “Миний энэхүү шавь Махакаашяпа ирээдүйн ертөнцөд үнэхээр хоёр зуун арван сая тоот Ялж Төгс Нөгчсөн Бурхатад өргөл өргөх, сүсэглэн бишрэх, хүндэтгэх, магтан дуулах.” эсвэл “Махакатя-Яна бээр магад ирэх цагийн ертөнцөд олон тоот арга хэрэгслээр найман мянган дүнчүүр Бурхан болж туслах.” зэргээр шавь тус бүртээ Бурханд өргөл өргөж, хүндэтгэхийн ач холбогдлыг агуулга бүрт нь тохируулан нарийвчлан айлдсан байдаг.

Тэглээ ч бидний хувьд “Гурван тэрбум” болон “Найман наяд” гэсэн тоо томшгүй олон тоот “Бурханд өргөл өргөх” гэвээс сонсох төдийд л өөр ертөнцийн үлгэр мэтээр бодно. “Ирээдүй”, “Хойд нас” гэж байдаг болохоор дахин төрж, үхэхийн хүрд мэт ээлжлэн үргэлжлэх утга ч бий байх, мөн үүнийг Энэтхэгийн онцгой нэгэн гайхамшигт хэллэг гэж ойлгож болох ба өөр дээр маань бодитойгоор биелж чадна гэж бодох аргагүй.

Мөн бид бүгд Шагжамүни Бурхан мэт гэгээрсэн нэгэнээ болон нас нөгчсөн хүнийг “Бурхан”, “Бурхан болох” гэдэг. Тэр утгаараа бидний хувьд “Бурхан”-ны сонгодог хэлбэр нь “Шагжамүни Бурхан” тул “Найман наяд Бурхан” гэх мэтээр Бурханыг хязгааргүй олон байдаг гэсэн утгыг ч гэсэн ойлгоход төвөгтэй зүйлийн нэг билээ.

Гагцхүү хүн буюу Шагжамүни Бурхан нь гэгээрэх хүртэлээ учрах нэгэн ба сургаалийг хүлээн авагч хүн, цаашлаад жинхэнэ үнэнийг түгээн дамжуулах аялалд учирсан бүх хүмүүсийг “Бурхан” гэж хүлээж авах байр сууринаас авч үзэх юм бол түрүүчийн Судрын үг өгүүлбэр өөрөөр харагдаж ирэх болно. Мөн өдөр бүр уулзах хүн нэг бүрийг Шагжамүни Бурхан лугаа адил “Бурхан” хэмээн хүлээж авахад энэхүү судрын нэг хэсэг бидний амьдралын өдөр тутмын бодит асуудал болон тулгарах бус уу.





“Өргөл өргөх”-ийн үндэс нь сэтгэл зүрхээ зориулах

Нүднийхээ өмнө байгаа хүнийг “Бурхан” гэж харах тухайд хэлэхэд Ринзай шашныг үндэслэгч багш бээр ийн өгүүлжээ.

“Хэрэв та нар Бурханыг гаднаас эрэлхийлэх сэтгэлгээгээ гэсэн бол тэр чигээрээ Бурхан юм. Одоо миний нүдний өмнө энэхүү сургаалийг сонсож буй та бүхэн Бурханаас өөрцгүй.”

Бясалгагч нөхөддөө зориулан хэлэхэд би бол угаас цэвэр ариун сэтгэлт Бурхан гэж мэдрэх юм бол өөрөө ч Бурхан, таны өмнө буй харилцагч тань ч Бурхан бөгөөд түүнийг “Уулзан учрах хүн бүр Бурхан” хэмээн итгэж, хүлээн зөвшөөрөхтэй ижил юм.

Хүн нас барсан хүнд алга хавсарч болох ч, амьд хүнтэй огт тэгж чаддаггүй гэж ярьдаг ба үхсэн нь ч, амьд нь ч ялгаагүй “Бурхан” юм бол нүднийхээ өмнөх хүнд “Өргөл өргөх, хүндэтгэх, магтан дуулах” сэтгэлээ илэрхийлэн “Өргөл өргөх” тухай номлох нь ч гайхамшигтай яриа бишээр үл барам мэдээжийн ойлгомжтой зүйл юм.

Тэгвэл бодитойгоор яах ёстой вэ – Нэгэн Бурханд талархсан чин сэтгэлээ зориулан “Өргөл өргөх” дотроос хамгийн чухал нь сургаалийг биелүүлэх гэж үздэг. Тэгсэнээр сургаал бол жинхэнэ бодит үнэн зүйл гэдгийг мэдэх болно. Шагжамүни Бурхан лугаа адил нигүүлсэхүйн сэтгэлээр өдөр бүхнийг үдэх болно. Эелдэгээр хэлбэл “Хүний зовлон, ганцаардлыг багасгаж, сайн сайхан зүйлийг их болгохын төлөө” хэмээн залбирч бусдын төлөө сэтгэлээ зориулах юм.

Тэр бол өөрийнхөө урд байгаа “Бурхан”-нд үзүүлж буй сүсэг бишрэл ба цаашлаад бясалгал, Бурханы номд шамдсанаар олж авсан жинхэнэ үнэнийг айлдсан Шагжамүни Бурхан, өөрөөр хэлбэл “Бурхан багш”-д үзүүлэж буй талархал, хүндэтгэлийн сэтгэлийг агуулсан өргөл болох юм. Ингэж бид бүхэн бусдын сайн сайхны төлөө гэсэн сэтгэл нь ундарсан хүн болохтой уялдаад “Бурхан”-нд ойртох болно.

Бид бүгдийг нэгжээд даавуутай зүйрлэвээс бүгд адил “Бурхан” болох шинж чанарыг агуулсан гайхамшигт “Даавуу” юм. Тэнд нигүүлсэл, сайхан сэтгэлийн бодит биелэлээ олсон хэлбэр агуулагдаж байваас “Бурхан” хэмээх хамгийн ариун дээд “Орхимж” болж ч мэдэх юм.

«Косей»2019 оны 10 дугаар сарын дугаар



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Эрдэнэсийн суварга үзүүлснийг өгүүлэх 11 дүгээр бүлэг (Эхний хагас)



Өмнөх “Номын багш хэмээх 10 дугаар бүлэг”-г Шагжамүни Бурхан бээр хожмын амьдралд Цагаан Лянхуа Судрын номлолыг түгээн дэлгэрүүлэгч нь сэтгэлээ удирдан чиглүүлэх тухай болон номлолыг зөв айлдах хүний хүлээн зөвшөөрвөл зохих давуу талын тухай тайлбарласан билээ.

Олон Эрдэнэт Түүнчлэн Ирсэний баталгаа

Тэр тухай айлдаж дуусангуут нүдний өмнө гэрэл цацарсан их суварга хормын дотор газраас урган гарч ирж, тэнгэрт өөд сүндэрлэв. Түүгээр ч үл барам тэрхүү эрдэнэсийн суварга дотроос үлэмжийн чанга дуу цуурайтаж, “Гайхалтай. Үнэхээр гайхалтай. Ялж Төгч Нөгчсөн Шагжамүни Бурхан, бүгд адил Бурхан болж чадна хэмээх бүх зүйлийг нэвт харах билиг оюун (Эн тэнцүүд үзэх их билиг) -нд суурилж, бүх хүнийг Бодисатвагийн зам мөрд оруулах номлол (Бодисатвагийн сургаал) болох олон Бурхадын нууц нь хэмээн хамгаалж (Гайхамшигт ном Цагаан Лянхуа Судар) ирсэн Оройн Дээд Цагаан Лянхуа сургаалыг хамаг амьтны төлөө номлолоо. Тэр дагуу болжээ. Шагжамүни Бурханы айлдсан нь бүгд үнэн болой.” хэмээн магтаж, тэрхүү сургаалыг үнэн бодитой болохыг баталсан.

Хүмүүс үгээр илэрхийлэхийн аргагүй ихээр талархаж байсан ба түүний дундаас Их Номлохуйд Баясагч Бодисадва “Ямар учир шалтгаанаар энэхүү эрдэнэсийн суварга газраас гарч ирж, ийм их дуу чимээ гаргав” гэж асуухад нь Шагжамүни Бурхан “Энэхүү эрдэнэсийн суварга дотор Түүнчлэн Ирсэний бүх бие бий.” хэмээн хариулдаг.

Эрдэнэсийн суварга бол бурханлаг чанарын бэлгэ тэмдэг



Энэ үгийн утга үнэхээр чухал. Түүнчлэн Ирсэн гэдэг нь “Үнэнээс ирсэн хүн” гэсэн утгатай тул Түүнчлэн Ирсэний бүх бие энэхүү суварга дотор илбэдүүлэн орсон гэдэг бол “Үнэн бүтэн үеэрээ энд заларч буй.” гэсэн утгатай.

Үнэн гэдэг бол энэ сансарын бүх юмс оршин тогтнож буй “Сургаал, ном” юм. Өөрөөр хэлбэл “Үндэс язгуурын сургаал” буюу “Туйлын үнэн”. Үүнийг хүнд хамааруулж хэлэх юм бол үндсэн хэлбэр болох “Бурханлаг чанар”-ыг илэрхийлнэ. Энэхүү эрдэнэсийн суварга гэдэг нь “Бурханлаг чанар”-ын бэлгэ тэмдэг байхаас өөр аргагүй зүйл билээ.

Тэрхүү суварга тэнгэрээс бууж ирэлгүй, газраас хөвөн гарсан гэдэг нь мөн маш чухал утгатай. “Тэнгэр” гэж хүний ертөнцөөс ангид төсөөллийн ертөнцийг хэлж байгаа ба “Газар” гэдэг нь хүнтэй нягт холбогдсон бодит ертөнцийг хэлж байна. Улмаар бурханлаг чанар гэдэг бол бусдаас (Тэнгэр) олж авах бус бодитойгоор бидэнд байдаг (Газар) зүйл учраас бид түүнийг зөвхөн биеэрээ мэдрэх нь л чухал гэдгийг илэрхийлжээ.



Гайхамшигт ном Цагаан Лянхуа Судрын сургаал нь энэхүү жинхэнэ үнэнд үндэслэж, хүмүүсийг эн тэнцүү бурханлаг чанарыг нь мэдрүүлэн баталсанаар энэ ертөнцийг аврах гэсэн аливаа Бодисатвагийн зам мөрийн сургаал бөгөөд Бурхад хамгийн чухал сургаалиа хэмээн үзэж шүтдэг. Түүнийг Шагжамүни Бурхан анх удаа хамаг амьтны тусын тулд айлдсан учраас энэ бол талархаад талархаад баршгүй ариун нандин үйл ба хүн төрөлхтний хувьд хэдэн мянган үеийг туулсан чухал сургаал юм. Тиймээс бурханлаг чанарын их суварга дотроос ийм их дуу чимээ гарсан билээ.

Дараа нь Шагжамүни Бурхан бээр “Эрдэнэсийн суваргын эзэн нь алс холын дорно зүгийн орноос гарч ирсэн Олон Эрдэнэт Түүнчлэн Ирсэн хэмээх Бурхан бөгөөд тэрхүү Бурхан нь Бодисатва байх үедээ “Өөрөө Бурхан болсоныхоо дараа аль ч ертөнцөд Цагаан Лянхуа Судрыг номлож чадах аваас тэрхүү сургаалийг сонсохын тулд сургаал айлдахын өмнө их суваргаас гарч ирж, түүний жинхэнэ үнэнийг баталж, магтан дуудъя” хэмээн их тангараг өргөөд, Бурхан болоод ертөнцийг туулах үедээ “Миний бүх биеийг шүтэе гэж бодож байвал нэгэн их суваргыг босгоорой.” хэмээн хүссэн.” гэсэн байдаг.

Олон Эрдэнэт Түүнчлэн Ирсэн гэдгийг “Алс холын дорно зүгийн орны Бурхан багш” гэсэн үгээр илэрхийлсэн ба бодитойгоор энэ ертөнцөд гарч ирсэн, бодит биетэй Бурхан биш юм. “Үнэн тэр чигээрээ”, “Жинхэнэ үнэний бүхэл дүр төрх (Жинхэнэ үнэний төгс дүр төрх)”-ийг Түүнчлэн Ирсэн гэж хэлсэн байдаг. Үнэн тэр чигээрээ, жинхэнэ үнэний төгс дүр төрх гэх зэргээр хэлж байгаа ч тухайн үеийн олон нийт итгэж үнэмшээгүй тул Түүнчлэн Ирсэн гуай хэмээн хүн шиг хэлбэртэй болгоод Шагжамүни Бурхан айлдсан учиртай.

Хэзээ ч, хаана ч нэгэн хэвээрээ хувирашгүй байх нь жинхэнэ үнэний туйлын үнэн. Энэ сансар анх үүссэнээс хойш хэзээ ч, хаана нь ч тэрхүү жинхэнэ үнэн хувирашгүйгээр оршин буй. Тэрхүү жинхэнэ үнэн нь янз бүрийн хэлбэрээр илэрдэг ба тэрхүү олон янзын илрэлд түшиглэсэн нэгдсэн нэг дүр төрхийг Түүнчлэн



Ирсэнийн дүрээр харуулсан. Тиймээс “Олон эрдэнэсийг хураасан Түүнчлэн Ирсэн” гэсэн нэртэй байгаа билээ.

Ингэхэд Олон Эрдэнэт Түүнчлэн Ирсэний үгэнд “Их суваргыг босгоё” гэсэн нь “Хамаг амьтны буханлаг чанарыг тунхагъя” гэсэн утгатай. Тэр бол Олон Эрдэнэт Түүнчлэн Ирсэн (Туйлын үнэн)-нд үзүүлсэн хамгийн том дурсгал юм. Учир нь жинхэнэ үнэний илэрхийлэл болох үүднээсээ туйлын үнэнг тийнхүү тунхаглагдахыг хүсэмжилсэн бөгөөд хамаг амьтны бурханлаг чанарыг тунхаглан батлах нь жинхэнэ үнэн төгс дүр төрхөөрөө энэ ертөнцөд илэрч гарч ирэхээс өөрцгүй учраас тэр билээ.

Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X. 110-116

Living the
 **LOTUS**

Бие ондоо ч сэтгэл нэг гэсэн уриатайгаар сургаалаа түгээх нь

Өнгөрсөн Намрын баяр буюу нэг хөлгөний номын баяр зохион байгуулагддаг сар айлчлан ирлээ. Наму мёо хоо рэн гэ кёо тарний дуун доор бүх хүн сэтгэлээ нэгтгэж, сургаалыг түгээх тангарагаа дахин шинэчлэх үе ирээд байна.

Нивано ерөнхийлөгч энэ сарынхаа айлдварт “Эш үзүүлснийг үзүүлэх 6-р бүлэг” –ээс иш татаж, би өөрөө ч бурхан, миний эргэн тойрны хүмүүс ч бурхан гэдгийг хүлээн зөвшөөрөх, мөн бурхандаа өргөх хамгийн том өргөл бол сургаалаа хэрэгжүүлэх явдал юм гэж сургажээ.

“Аль болох олон хүнд Цагаан лянхуа судард дурьдсан хүмүүний амьдралын мөн чанарыг ухааруулж, жинхэнэ аз жаргалыг өөрийн болгох арга замыг гарт нь атгуулах” гэдэг үүсгэн байгуулагчийн туйлын хүсэл байсан.


Энэ сар бол үүсгэн байгуулагчийн хүслийг өөрийн хүсэл болгож, хамгийн дээд өргөл болох сургаалыг хэрэгжүүлэхийг хичээж, сургаалыг түгээх ариун үйлд өөрийгөө зориулъя гэж бодож байна.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: info@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 POBox 33636, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 FAX: 1-650-359-6437
 Email: info@rksf.org URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-262-4437
 Email: info@rkina.org URL: <http://www.rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692042, San Antonio, TX 78269, USA
 TEL: 1-210-561-7991 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 FAX: 1-253-945-0261
 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059, West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL/FAX: 880-31-626575

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Patiya

China Clinic, Patiya Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni,

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia

TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

2F Ikh Mandal building, Khurenbulag bag, Bayan-Undur sum,
Orkhon province, Mongolia

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia

TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Paris

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>